

**ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН  
ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг олгох, олгохоос татгалзах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон нарийвчилсан харилцааг зохицуулахад оршино.

/Тайлбар: “үнэт металл” гэж Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт заасныг, “үнэт чулуу” гэж Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт тус тус заасныг ойлгоно/

**Хоёр. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа  
эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн шаардлага**

2.1. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргасан этгээд нь хуулийн этгээд бол дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1. Хуулийн этгээдээр бүртгүүлж, улсын бүртгэлийн байгууллагаас улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байх;

2.1.2. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан байх;

2.1.3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн нь эх үүсвэр нь иргэн, хуулийн этгээдийн татвар төлсний дараах хууль ёсны орлого болон хуулиар зөвшөөрсөн бусад орлогоос бүрдсэн байх;

2.1.4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэрийг зээлийн хөрөнгөөр бүрдүүлээгүй байх;

2.1.5. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах ажлын байртай байх;

2.1.6. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах тоног төхөөрөмжтэй байх;

2.1.7. Хоёроос доошгүй ажилтантай байх;

2.1.8. Хорооноос баталсан “Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-д заасан шаардлагыг хангасан байх;

2.1.9. 20 сая болон түүнээс дээш гүйлгээ хийсэн харилцагчийн талаарх мэдээллийн бүртгэлийг хөтөлдөг байх;

2.1.10. Харилцагчийг тодорхойлох албан ёсны бичиг баримт болон гүйлгээний баримт, сэжигтэй гүйлгээний тайлангуудтай холбоотой бичиг баримтуудын хуулбарыг 5-аас доошгүй жил архивлан хадгалдаг байх;

2.1.11. Хуульд заасан дүнгээс дээш дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн тохиолдолд харилцагчийг таньж мэдэх, баримт бичгийг хадгалдаг байх;

2.1.12. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт заасан асуудлыг тусгасан дотоод хяналтын хөтөлбөртэй байх;

2.1.13. Дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх орон тооны ажилтантай байх;

2.1.14. Хуулийн этгээд, иргэнд худалдах үнэт металл, үнэт чулуу, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийг сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар сорьц тогтоолгон баталгаажуулсан байх;

2.1.15. Эрхлэх үйл ажиллагааны чиглэлээр 3-аас доошгүй жилийн бизнес төлөвлөгөөтэй байх;

2.1.16. Журамд заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэт бүрдүүлэн Хороонд ирүүлсэн байх.

2.1.17. Гадаадын хөрөнгө оруулалттай үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч этгээд нь үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эрхлэхээр өргөдөл гаргаж байгаа бол Хөрөнгө оруулалтын тухай хууль болон энэ журамд заасан шаардлагыг хангах бөгөөд Хороо нэмэлт шаардлага тавьж болно.

2.2. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргасан этгээд нь хувь хүн бол дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.2.1. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан байх;

2.2.2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь хууль ёсны орлогоос бүрдсэн байх;

2.2.3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэрийг зээлийн хөрөнгөөр бүрдүүлээгүй байх;

2.2.4. Хорооноос баталсан “Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-д заасан шаардлагыг хангасан байх;

2.2.5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1-д заасан дотоод хяналтын хөтөлбөртэй байх;

2.2.6. Бусад

2.3. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах нийтлэг шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

2.3.1. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, Хорооноос баталсан журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

2.2.2. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуулийн этгээд бол энэ журмын 2.1.2, 2.1.5-2.1.15-т заасан шаардлагыг, хувь хүн бол энэ журмын 2.2.1, 2.2.4-2.2.6-д заасан шаардлагыг байнга хангаж ажиллана.

2.2.3. Хорооноос тогтоосон үйл ажиллагаанд тавигдах шаардлага, шалгуурыг хангаж ажиллана.

2.2.4. Хорооноос баталсан журмын дагуу жил бүр болон тухай бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тогтоосон хэмжээгээр журамд заасан хугацаанд төвлөрүүлнэ.

2.2.5. Холбогдох хууль тогтоомж, журам, зааварт заасны дагуу Хорооны хяналт, шалгалтад хамрагдана.

2.2.6. Сүүлийн 3 жилийн хугацаанд Эрдэнэсийн сангийн тухай хуульд заасны дагуу Монголбанкинд үнэт металл тушаасан байх.

2.2.7. Бусад

### **Гурав. Тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах**

3.1. Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:

3.1.1. Үнэт металлын арилжаа эрхлэх;

3.1.2. Үнэт чулууны арилжаа эрхлэх.

3.2. Үнэт металл, үнэт чулууны эдлэлээр арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:

3.2.1. Үнэт металлын эдлэлээр арилжаа эрхлэх;

3.2.2. Үнэт чулууны эдлэлээр арилжаа эрхлэх.

3.3. Энэ журмын 3.1, 3.2-д заасан үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд дагнан эсхүл хавсран эрхэлж болно.

3.4. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/ олгохыг хүссэн өргөдөл, баримт бичгийг Хорооны холбогдох ажилтан хянаж, зөвлөгөө өгөх бөгөөд тухайн өргөдөл, баримт бичгийн бүрдүүлбэр, шаардлагыг хангасан гэж үзвэл Хорооны бичиг хэрэгт бүртгүүлнэ.

3.5. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эсэхийг тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн өргөдөл, холбогдох баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэт, холбогдох хууль тогтоомж болон энэхүү журамд заасан шаардлагуудыг хангаж Хороонд ирүүлсэн өдрөөс эхлэн ажлын 21 хоногийн дотор шийдвэрлэнэ.

3.6. Энэ журмын 3.5-д заасан тусгай зөвшөөрлийг олгох эсэх асуудлыг Хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ.

3.7. Хороо өргөдлийн мэдээлэл, бүрдүүлсэн баримт бичигтэй холбоотой нэмж тодруулах шаардлагатай гэж үзвэл өргөдөл гаргасан этгээдэд албан бичгээр мэдэгдэж, нэмэлт мэдээлэл, баримт бичгийг шаардаж болох бөгөөд нэмэлт баримт бичгийг хууль, журамд заасан шаардлагыг ханган ирүүлсэн өдрөөс эхлэн энэ журмын 4.7-д заасан хугацааг тооцно.

3.8. Хороо энэ журмын 3.6-д заасан тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгоно.

3.9. Хороо энэ журмын 3.6-д заасан тусгай зөвшөөрлийг бичгээр олгох бөгөөд түүнд Аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан зүйлийг тусгана.

3.10. Энэ журмын 3.6 дахь хэсэгт заасан Хорооны шийдвэр болон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримтыг үндэслэн тухайн этгээдэд тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгож, нэгдсэн бүртгэлд бүртгэн, зохих зааврын дагуу хувийн хэрэг нээн хөтөлнө.

3.11. Тусгай зөвшөөрөл олгосонтой холбоотойгоор гарсан өөрчлөлтийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, нотариатаар гэрчлүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээний болон компанийн дүрмийн хуулбар, эхсүл эх хувийг тусгай зөвшөөрөл эзэмшигч Хороонд ирүүлнэ.

3.12. Хороо дараах үндэслэлээр үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана:

3.13.1. Өргөдөл гаргагч нь хуулийн этгээд бол энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангаагүй;

3.13.2. Тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн болох нь тогтоогдсон;

3.13.3. Холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан бусад нөхцөл, шаардлагыг хангаагүй.

3.13.4. Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд Хороо энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг өргөдөл гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

3.13.5. Хороо хуурамч баримт бичиг бүрдүүлсэн үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан бол татгалзсанаас хойш 1 жилийн дотор өргөдөл гаргасан хуулийн этгээд, иргэнээс тус тус Хороо үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийг арилжих үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авахгүй.

## **Дөрөв. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох**

4.1. Хороо үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр түдгэлзүүлнэ:

4.1.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн, тэдгээрт заасан тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн;

4.1.2. Тухайн үйл ажиллагааны ирүүлбэл зохих санхүүгийн тайлан, мэдээг 4 улирал дараалан Хороонд ирүүлээгүй;

4.1.3. тухайн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг авсанаас хойш 3 улирал дараалан үйл ажиллагаа эрхлээгүй;

4.1.4. Жил бүр Хороонд төлөх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төлөх хугацааг 3 сараас дээш хугацаагаар хэтрүүлсэн;

4.1.5. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангаж ажиллаагүй;

4.1.6. Үйлчлүүлэгч болон иргэдийн ашиг сонихролд хохирол учруулахуйц нөхцөл байдал үүссэн;

4.1.7. Холбогдох хууль тогтоомжийн дагуу Хорооноос өгсөн даалгаварыг биелүлээгүй;

4.1.8. Хорооноос баталсан “Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-д заасан заасан хувь хүн, хуулийн этгээд нь тус журмын шалгуурын хангахгүй болсон, Хорооноос тохироижтой бус этгээд гэж үзсэн;

4.1.9. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

4.2. Хороо тусгай зөвшөөрлийн хугацааг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.

4.3. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхээс өмнө Хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэлийг заасан мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлж, хүргэсэн огноог тэмдэглэнэ.

4.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ журмын 5.3-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзсэн тайлбараа Хороонд ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

4.5. Хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн шийдвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

4.6. Хорооноос үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх шийдвэр гарсан өдрөөс хойш тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийг сэргээх шийдвэр гарах хүртэл үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийг арилжих үйл ажиллагаа эрхлэхгүй.

4.7. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд түдгэлзүүлсэн үндэслэл болсон зөрчил, дутагдлыг арилгаж, хэвийн үйл ажиллагаагаа хангасан тохиолдолд тухайн этгээдийн хүсэлтийг үндэслэн Хороо тусгай зөвшөөрлийг сэргээж болно.

4.8. Тусгай зөвшөөрлийг сэргээлгэх хүсэлтэй этгээд нь тусгай зөвшөөрлийг сэргээж өгөхийг хүссэн хүсэлт, энэхүү журмын 7 хавсралтад заасан баримт бичгийн бүрдэл, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэл болсон зөрчил дутагдлыг арилгасан болохыг нотлох баримт бичгийн хамт Хороонд ирүүлнэ.

4.9. Хороо дараах үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

4.10. Хороо энэ журмын 4.8-д заасан баримт бичгийг ирүүлснээс хойш 14 хоногийн дотор хянаад, тусгай зөвшөөрлийг сэргээх эсэх асуудлыг Хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ.

4.11. Хороо дараах үндэслэлээр үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно. Үүнд:

4.11.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

4.11.2. тусгай зөвшөөрөл эзэмшигч татан буугдсан;

4.11.3. энэ журмын 4.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн зөрчил, дутагдлыг тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд арилгаагүй;

4.11.4. тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

4.11.5. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

4.11.6. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй;

4.11.6. бусад.

4.12. Энэ журмын 4.11.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөл хүчингүй болгох хүсэлт гаргаж буй тохиолдолд энэхүү журмын 8 дугаар хавсралтад заасан баримт бичгийг тусгай зөвшөөрөл хүчингүй болгохыг хүссэн хүсэлтийн хамт Хороонд ирүүлнэ.

4.13. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохоос өмнө Хороо тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох болсон үндэслэлийг заасан мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлж, хүргэсэн огноог тэмдэглэнэ.

4.14. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ журмын 4.13-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тайлбараа Хороонд ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

4.15. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох эсэх асуудлыг Хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ.

4.16. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэр гарсанаас хойш 3 хоногийн дотор энэ талаар тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч байсан этгээдэд албан бичгээр мэдэгдэнэ.

4.17. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэр гарсан тохиолдолд Хороо энэ талаар олон нийтэд мэдээлэн, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, хүчингүй тэмдэг даран, тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувийн хэрэгт хийж холбогдох хууль тогтоомжийн дагуу Хорооны архивт шилжүүлнэ.

4.18. Хорооноос тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болсон шийдвэр гарсанаас хойш үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхэлсэн бол тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэж холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

**Тав. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах**

5.1. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь уг үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой дараах өөрчлөлтүүдийг оруулахын өмнө тухай бүр Хороонд мэдэгдэж, зөвшөөрөл авна. Үүнд:

5.1.1. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах;

5.1.2. Салбар, төлөөлөгчийн газар нээх;

5.1.3. Оноосон нэрээ өөрчлөх.

5.2. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай бүр аливаа гүйлгээ хийгдэхээс өмнө зөвшөөрөл авах бөгөөд дараах шаардлага тавигдана. Үүнд:

5.2.1. Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн мөнгөн хөрөнгө нь хууль ёсны орлогоос бүрдсэн байх;

5.2.2. Хувьцаа эзэмшигч өөрчлөгдөж байгаа бол Хорооноос баталсан “Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-д заасан шаардлагыг хангасан байх;

5.2.3. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн хувьцааг худалдан авч буй хувьцаа эзэмшигчийн хөрөнгийн гарал үүсэл нь хууль ёсны орлогоос бүрдсэн байх;

5.2.4. Энэ журмын 2 дугаар хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, 9 дүгээр хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлсэн байх.

5.3. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд дараах хэлбэрээр өөрчлөлт оруулж болно. Үүнд:

5.3.1. Хувьцаа эзэмшигчдийн мөнгөн хөрөнгөөр;

5.3.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч үндсэн үйл ажиллагааны хуримтлагдсан ашгаар нэмж хөрөнгө оруулах;

5.3.3. Хувьцаа нэмж гаргах.

5.4. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь салбар, төлөөлөгчийн газар нээх зөвшөөрөл олгоход дараах шаардлага тавигдана. Үүнд:

5.4.1. Үйл ажиллагаагаа явуулах нутаг дэвсгэрийн хязгаарлалтаа тодорхойлсон, хаяг байршил нь тодорхой, байнгын ажлын байртай байх;

5.4.2. Салбарын удирдлагаар ажиллах этгээд нь Хорооноос баталсан “Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-д заасан шаардлагыг хангасан байх;

5.4.3. Үйл ажиллагааг хэвийн явуулах тоног төхөөрөмжтэй байх;

5.4.4. Салбар, төлөөлөгчийн газрын дотоод хяналт болон бусад үйл ажиллагааг зохицуулах журамтай байх;

5.4.5. Салбар, төлөөлөгчийн газар нь компанийн ерөнхий захиргаа болон бусад нэгжүүдтэйгээ мэдээллийн нэгдсэн нэг сүлжээнд холбогдож, мэдээлэл, тайлагнал дамжуулдаг байх;

5.4.6. Тухайн нутаг дэвсгэрт салбар нээн ажиллуулахтай холбогдсон зах зээлийн судалгаатай байх;

5.4.7. Энэ журмын 2 дугаар хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, 10 дугаар хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлсэн байх;

5.4.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь банк бол банкны нэгжээр дамжуулан үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийг арилжих үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагаа эрхэлж болно.

5.7. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь оноосон нэр өөрчлөх зөвшөөрөл олгоход дараах шаардлага тавигдана. Үүнд:

5.7.1. Нэрээ өөрчлөх нь үйлчлүүлэгчдэд сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхгүй байх;

5.7.2. Энэ журмын 2 дугаар хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, 11 дүгээр хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлсэн байх.

5.8. Зөвшөөрөл авахаар хүсч ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг холбогдох ажилтан хянаж, зөвлөгөө өгөх бөгөөд тухайн өргөдөл, баримт бичгийг бичгийн бүрдүүлбэр, шаардлагыг хангасан гэж үзвэл Хорооны бичиг хэрэгт бүртгүүлнэ.

5.9. Зөвшөөрөл хүсч ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг хянаж, ажлын 30 хоногийн дотор Хороо шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд хугацааг 14 хоногоор сунгаж болно.

5.10. Зөвшөөрөл олгох тухай Хорооны шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж, баталгаажуулсны дараа Улсын бүртгэлийн байгууллагад холбогдох бүртгэлийг хийлгэнэ.

5.11. Хуулийн этгээд нь Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн шинэчилсэн буюу өөрчлөлт оруулсан дүрмийн эх хувь, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг Хороонд ирүүлнэ.

5.12. Салбар, төлөөлөгчийн газар нь Хорооноос олгогдсон зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэх ба салбар, төлөөлөгчийн газар тус бүр нь зөвшөөрлийн гэрчилгээтэй байна.

5.13. Хорооны зөвшөөрөлгүйгээр энэ журмын 5.1-т заасан өөрчлөлтүүдийг оруулсан тохиолдолд зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэн холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

5.14. Хорооноос тавьсан шаардлагыг хангаагүй тохиолдолд зөвшөөрөл олгохоос татгалзах бөгөөд энэ талаар гарсан Хорооны шийдвэрийг шийдвэр гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор хуулийн этгээдэд албан бичгээр хүргүүлнэ.

5.15. Салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгож зөвшөөрлийн гэрчилгээг хураан авна. Үүнд:

5.15.1. Салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгах хуулийн этгээдийн шийдвэр;

5.15.2. Холбогдох хууль тогтоомжид нийцээгүй үйл ажиллагаа явуулсан, Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй болон салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа нь тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварт хүндрэл учруулахаар байгааг тогтоосны үндсэн дээр гаргасан Хорооны даргын шийдвэр;

5.15.3. Хороонд салбар, төлөөлөгчийн газраа бүртгүүлснээс хойш 6 сарын хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй;

5.15.4. Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, салбар төлөөлөгчийн газарт тавигдах нөхцөл, шаардлагыг хангаагүй;

5.15.5. хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр.

5.4. Хорооны шийдвэр болон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримтыг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад салбар, төлөөлөгчийн газрын талаарх тэмдэглэлийг хийж баталгаажуулах бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигчид нэгжийн гэрчилгээг олгоно.

5.5. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийг арилжих үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь салбар, төлөөлөгчийн газрыг

дараах үндэслэлээр Хорооны шийдвэрээр бүртгэлээс хасч, тухайн салбар, төлөөлөгчийн газрын гэрчилгээг хураан авч, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд 3 хоногийн дотор тэмдэглэл хийнэ. Үүнд:

5.5.1. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн шийдвэрээр;

5.5.2. салбар, төлөөлөгчийн газар нь санхүүгийн хүндрэлд орсон, холбогдох хууль тогтоомжид нийцээгүй үйл ажиллагаа явуулсан;

5.5.3. Хороонд салбар, төлөөлөгчийн газраа бүртгүүлснээс хойш 6 сарын хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй;

5.5.4. Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, салбар төлөөлөгчийн газарт тавигдах нөхцөл, шаардлагыг хангаагүй;

5.5.5. хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр.

### **Зургаа. Хяналт хариуцлага**

6.1. Хороо энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах бөгөөд зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.